

Газрын гэрчилгээний бүртгэл



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: 263727

И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2021.04.09 № 2/1791

танай -ны № -т

Программд мэдээлэл оруулах тухай

Боловсрол, шинжлэх ухааны салбарын хэмжээнд газар эзэмшил, ашиглалтын асуудлаар нэгдсэн судалгаа хийж, дүгнэлт гаргах, газар эзэмшил ашиглалттай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар танилцуулахаар үүрэг болгосон.

Энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор Боловсролын удирдлага, мэдээллийн сан /ESIS/-д газрын эзэмшил, ашиглалттай холбоотой нэмэлт талбарыг шинээр хөгжүүлж, ашиглалтад оруулсан тул төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагын газар эзэмшил, ашиглалттай холбоотой мэдээллийг уг программд үнэн зөв, бүрэн оруулж 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор орон нутгийн хэмжээнд шуурхай зохион байгуулж ажиллахыг мэдэгдье.

Газрын эзэмшил, ашиглалттай холбоотой мэдээллийг программд сургууль, цэцэрлэгийн менежерийн эрхээр шивж оруулах ба харьяа сургууль, цэцэрлэгийн мэдээллийг үнэн зөв оруулсан эсэхэд хяналт тавьж, мэдээллийг баталгаажуулахыг аймаг, дүүргийн Боловсролын газар хэрэгжүүлнэ.

Энэхүү мэдээллийн системд үнэн бодит байдлыг хангаж, цаг хугацаанд нь зохион байгуулж, хяналт тавьж ажиллахад аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага анхаарч ажиллах шаардлагатай.

Программтай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвийн 75778080 утас болон info@edu.mn хаягаар, тус яамны Мэдээллийн технологи, статистикийн төвийн ахлах мэргэжилтэн Н.Мөнхсанчир /Холбогдох утас:263600,96096596/-тай тус тус холбогдож авна уу.

ТӨРИЙН НАРИЙН БИЧИГЭЙН
ДАРГА

Д.БАТБААТАР



14219 2502

Газрын гэрчилгээ бүртгэлийн гарын авлага

Газар эзэмших, ашиглалтын бүртгэл хөтлөх ерөнхий үйл ажиллагааг дараах зурагт үзүүллээ.



Газрын бүртгэл хийх, газрын гэрчилгээний мэдээлэл оруулахдаа дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Газар эзэмшил, ашиглалттай холбоотой бүртгэлийг **Статистикийн удирдлага** цэсний **Газрын гэрчилгээний бүртгэл** гэсэн модульд бүртгэл хөтлөнө.
2. Газрын нэрийг бүртгэнэ.
3. Газрын гэрчилгээний дэлгэрэнгүй бүртгэлийг оруулж хадгалах үйлдэл хийнэ.